

# НИЙГМИЙН ДААТГАЛ

ГАРЫН АВЛАГА




Улаанбаатар хот  
2025 он


 undeg@ndaatgal.mn

 <http://www.ndaatgal.mn>

 sigomongolia

 Нийгмийн даатгалын ерөнхий газар

 Монгол Улс, 211238, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
4-р хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж 13/1,  
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

 7777-1289 Нийгийн даатгалын лавлах  
11-311131 Нийгийн даатгалын байгууллага, ажилтны үйл  
ажиллагаатай холбоотой санал, гомдол хүлээн авах

## АГУУЛГА

<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ</b> .....	6
Нийгмийн даатгалын төрөл, хэлбэр .....	7
Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ .....	7
Албан журмын даатгал .....	7
Сайн дурын даатгал .....	8
<b>ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ</b> .....	12
Өндөр насны тэтгэвэр .....	12
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр .....	18
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр .....	20
Тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг .....	22
<b>ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ</b> .....	23
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж .....	23
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж .....	25
Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж .....	26
Ажилгүйдлийн тэтгэмж .....	27
Тэтгэмж авах өргөдөл гаргах хугацаа, бүрдүүлэх баримт бичиг .....	29
<b>ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ</b>	
<b>ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ</b> .....	30
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр .....	31
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр .....	32
Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж .....	32
Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж .....	33
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох төлбөр .....	33
<b>ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ</b> .....	34
<b>НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРТ ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ</b>	
<b>ОЛОН УЛСЫН ХЭЛЭЛЦЭЭР</b> .....	35
БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд байгуулсан Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр .....	35
Монгол Улсын Засгийн газар БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр ....	36
Монгол Улсын Засгийн газар БНУУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр .....	37
Монгол Улсын Засгийн газар БНЧУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр .....	38
Монгол Улсын Засгийн газар БНПУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр .....	39
Монгол Улсын Засгийн газар БНТУ-ын Засгийн газар хооронд байгуулсан Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр .....	40
<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ</b> .....	41

ᠨᠢᠶᠭᠮᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯ ᠲᠤᠬᠠᠢ ᠣᠶᠢᠯᠭᠣᠯᠲ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ

**НИЙГМИЙН ДААТГАЛ** нь даатгуулагч, ажил олгогч, төрөөс хуульд заасны дагуу нийгмийн даатгалын санд урьдчилан шимтгэл төлж сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, жирэмсний болон амаржсаны амралт эдлэх, ажилгүй болоход өөрт нь, хэрэв даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүнд хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр олгох, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нийгмийн хамгааллын арга хэмжээ юм.



Хүний амьдралд тохиолдож болох жам ёсны болон гэнэтийн эрсдэлийн үед нийгмийн даатгал танд болон танай гэр бүлд учрах санхүүгийн хүндрэлийг даван туулахад тусална.



### ХҮНИЙ АМЬДРАЛД НИЙГМИЙН ШИНЖТЭЙ ЯМАР ЭРСДЭЛҮҮД ТОХИОЛДОЖ БОЛОХ ВЭ?

Өндөр наслах



Жирэмслэх, амаржих



Нас барах




Өвчлөх



Тэжээгчээ алдах




Хөдөлмөрийн чадвараа түр алдах



Ажилгүй болох



Хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар алдах



ᠠᠨᠢᠭᠮᠢᠶᠢᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯᠢᠨ ᠲᠦᠷᠦᠯᠤ, ᠬᠡᠯᠢᠪᠡᠷ

## НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР

Нийгмийн даатгал нь 5 төрөлтэй бөгөөд төрөл тус бүр нь бие даасан сантай байдаг. Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн болон төрөөс төлсөн шимтгэл, сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсны орлого, улсын төсвөөс олгох хөрөнгө, хуульд заасан бусад эх үүсвэрээс бүрдэнэ.



Нийгмийн даатгалд иргэд **албан журмаар** болон **сайн дураар** гэсэн 2 хэлбэрээр даатгуулж болдог.

ᠠᠯᠪᠠᠨ ᠵᠢᠷᠮᠤᠮᠤᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠤᠯᠠᠭᠴᠢ ᠭᠡᠵᠡ ᠬᠡᠨ ᠪᠡ?

## АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Өмчийн бүх хэлбэрийн болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага, түүний төлөөлөгчийн газар, Монгол улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн, консулын газар, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн нэгжид ажиллаж байгаа ажилтан болон хуулиар албан журмаар даатгуулахаар заасан Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, төрийн албан хаагчдыг албан журмын даатгуулагч гэнэ.

## АЖИЛ ОЛГОГЧИЙН БОЛОН АЛБАН ЖУРМЫН ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогч	Албан журмын даатгуулагч
Тэтгэврийн даатгал	8.5%	8.5%
Тэтгэмжийн даатгал	1.0%	0.8%
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.5%, 1.5%, 2.5%	-
Ажилгүйдлийн даатгал	0.5%	0.2%
<b>Нийт</b>	<b>10.5%, 11.5%, 12.5%</b>	<b>9.5%</b>

2023-2024 ОУ-ийн 10 сарын 10 өдөр

## САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Албан журмын даатгалд даатгуулснаас бусад хөдөлмөрийн насны бүх иргэн нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдах боломжтой.



## САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ



## САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ГЭРЭЭГ ХЭРХЭН БАЙГУУЛАХ ВЭ?

Нийгмийн даатгалд сайн дурын хэлбэрээр хамрагдахдаа Нийгмийн даатгалын байгууллага (байцаагч)-тай “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай” гэрээг цахимаар болон биечлэн ирж байгуулах бөгөөд гэрээндээ нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, орлогын хэмжээ, шимтгэл төлөх хугацаагаа тодорхой тусгаж өгдөг.

Сайн дурын даатгуулагч нь шимтгэл тооцох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоо тухайн үед мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, уг доод хэмжээг **7** дахин нэмэгдүүлснээс ихгүй байхаар мэдүүлнэ.



Хөдөлмөр нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооноос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох бүрд өөрчлөгдөх болно.

## ТЭТГЭВРИЙН БОЛОН ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТӨРӨӨС ХАРИУЦАН ТӨЛӨХ ЗОХИЦУУЛАЛТ

Гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа сайн дураар даатгуулагч эхийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцан төлдөг. Шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба дээрх арга хэмжээнд хүүхэд нь 3 нас хүрээгүй сайн дураар даатгуулагч эхчүүд хамаарна.

### Жишээ:

$792.000\text{₮} * 13.5\% = 106.920\text{₮}$  (Нийт төлбөл зохих шимтгэл)

Үүнээс: Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд төлбөл зохих шимтгэл:  
 $792.000 * 12.5\% = 99.000\text{₮}$

50 хувь нь - **49.500₮** (Тэтгэмжийн даатгалын сангаас эсхүл улсын төсвөөс хариуцан төлнө)

50 хувь нь - **49.500₮** (Даатгуулагч эх өөрөө төлнө)

ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл ( $792.000\text{₮} * 1\% = 7.920\text{₮}$ )-ийг даатгуулагч эх өөрөө хариуцан төлөх бөгөөд нийтдээ даатгуулагч эх **57.420** төгрөг, улсын төсвөөс **49.500** төгрөг төлнө.



Хэрэв даатгуулагч эх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр орлогоос сайн дурын даатгалын шимтгэл төлөх тохиолдолд дараах хэмжээгээр төлнө. Үүнд:

### 3 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДЭЭ АСАРЧ БАЙГАА ЭХИЙН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛЫН САН, УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУ- ЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	49,500	54,420
1,000,000	135,000	49,500	85,500
1,500,000	202,500	49,500	153,000
2,000,000	270,000	49,500	220,500
2,500,000	337,500	49,500	288,000
3,000,000	405,000	49,500	355,500
4,000,000	540,000	49,500	490,500
5,000,000	675,000	49,500	625,500
▲ 5,544,000	748,440	49,500	698,940

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй, нийгмийн даатгалын байгууллагатай сайн дураар даатгуулах гэрээ байгуулсан эх (эцэг)-ийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон улсын төсвөөс сар бүр төлнө.

#### Жишээ:

$792.000\text{₮} * 13.5\% = 106.920\text{₮}$  (Нийт төлбөл зохих шимтгэл)

Үүнээс: Тэтгэврийн даатгалд төлбөл зохих шимтгэл:

$792.000 * 11.5\% = 91.080\text{₮}$  (Улсын төсвөөс төлөх дүн)

Тэтгэмжийн болон ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл

( $792.000\text{₮} * 2\% = 15.840\text{₮}$ )-ийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

Хэрэв хүүхдээ асарч байгаа эх (эцэг) хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр орлогоос шимтгэл төлөх тохиолдолд дараах хэмжээгээр төлнө. Үүнд

### ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДЭЭ АСАРЧ БАЙГАА ЭХ, ЭЦГИЙН САЙН ДУРЫН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУ- ЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	91,080	15,840
1,000,000	135,000	91,080	43,920
1,500,000	202,500	91,080	111,420
2,000,000	270,000	91,080	178,920
2,500,000	337,500	91,080	246,420
3,000,000	405,000	91,080	313,920
4,000,000	540,000	91,080	448,920
5,000,000	675,000	91,080	583,920
▲ 5,544,000	748,440	91,080	657,360



Малчин, туслах малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон төлөх ба улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.

**Жишээ:**

$792.000\text{₮} * 13.5\% = 106.920\text{₮}$  (Нийт төлбөл зохих шимтгэл)

Үүнээс: Тэтгэврийн даатгалд төлбөл зохих шимтгэл:

$792.000 * 11.5\% = 91.080\text{₮}$

50 хувь нь - **45.540₮** (Улсын төсвөөс хариуцан төлнө)

50 хувь нь - **45.540₮** (Даатгуулагч өөрөө төлнө)

Тэтгэмжийн болон ҮОМШӨ-ний даатгалын шимтгэл ( $792.000\text{₮} * 2\% = 15.840\text{₮}$ )-ийг даатгуулагч өөрөө хариуцан төлнө.

Нийтдээ малчин өөрөө **61.380** төгрөг, улсын төсвөөс **45.540** төгрөгийг төлнө.



Хэрэв малчин, туслах малчин нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс дээгүүр орлогоос шимтгэл төлөх тохиолдолд дараах хэмжээгээр төлнө. Үүнд:

ӨӨРӨӨ МЭДҮҮЛСЭН ЦАЛИН ХӨЛС ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО	САРД ТӨЛӨХ ШИМТГЭЛИЙН ДҮН	УЛСЫН ТӨСВӨӨС ТӨЛӨХ ДҮН	ДААТГУУЛАГЧИЙН ТӨЛӨХ ДҮН
▼ 792,000	106,920	45,540	61,380
1,000,000	135,000	45,540	89,460
1,500,000	202,500	45,540	156,960
2,000,000	270,000	45,540	224,460
2,500,000	337,500	45,540	291,960
3,000,000	405,000	45,540	359,460
4,000,000	540,000	45,540	494,460
5,000,000	675,000	45,540	629,460
▲ 5,544,000	748,440	45,540	702,900



## ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

**Тэтгэвэр** гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдахад хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг хангах зорилгоор тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэврийн даатгалын сангаас даатгуулагчид тогтоож олгох тэтгэвэр нь доор дурдсан 3 төрөлтэй байна. Үүнд:

- Өндөр насны тэтгэвэр
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр



## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР

Өндөр насны тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь нийгмийн баталгааг нь хангах зорилгоор тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.


## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ

- 1** Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 2025 оны тухайд **22 жил** ба түүнээс дээш хугацаанд төлсөн, **60 насанд** хүрсэн эрэгтэй, **55 насанд** хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл тэтгэвэр тогтоолгох эрхтэй.
- 2** Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ **10-20 хүртэл** жил төлсөн, төрсөн ондоо харгалзах нас (хүснэгт 2)-нд хүрсэн даатгуулагч өөрөө хүсвэл, жишээлбэл: 20 жил шимтгэл төлсөн 1969 онд төрсөн эмэгтэй 56 нас 9 сар хүрсэн бол, 1964 онд төрсөн эрэгтэй 61 нас 9 сар хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй.
- 3** Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 ба түүнээс дээш хүүхдээ 6 нас хүртэл өсгөсөн ээж **20-иос доошгүй жил** тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол **50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.
- 4** Нийтдээ **20-иос доошгүй жил**, үүнээс газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд **10-аас доошгүй жил** ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй **50** насандаа, **7 жил 6 сараас** доошгүй жил мөн нөхцөлд ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй **45** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.
- 5** Нийтдээ **20-иос доошгүй жил**, үүнээс хөдөлмөрийн хүнд нөхцөлд **12 жил 6 сараас** доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эрэгтэй **55** насандаа, 10-аас доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй **50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.
- 6** Нийтдээ **20-иос доошгүй жил**, үүнээс малчнаар **15-аас доошгүй жил** ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй **55** насандаа, **12 жил 6 сараас** доошгүй жил малчнаар ажиллаж шимтгэл төлсөн эмэгтэй **50** насандаа тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

**ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙГ НАС ХАРГАЛЗАХГҮЙГЭЭР ТОГТООДОГ ОНЦЛОГ ТОХИОЛДЛУУД**

Даатгуулагчийн ажил мэргэжилтэй холбоотой нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоодог онцлог тохиолдол байдаг. Үүнд:

- Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагад нийтдээ **20-иос** доошгүй жил доорх ажил мэргэжлээр ажилласан, эсхүл нийтдээ **25 жил**, үүнээс тухайн мэргэжлээр **15-аас** доошгүй жил ажиллаж шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгож болно.



- Төмөр замын цэрэгжүүлсэн хамгаалалтын албанд 25-аас доошгүй жил ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгож болно.

**55/60 НАСАНДАА ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ДААТГУУЛАГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХУГАЦАА**

Тэтгэвэр тогтоолгох он	Шимтгэл төлсөн байвал зохих доод хугацаа
<b>2025</b>	<b>22 жил</b>
2026	22 жил 3 сар
2027	22 жил 6 сар
2028	22 жил 9 сар
2029	23 жил
2030	23 жил 3 сар
2031	23 жил 6 сар
2032	23 жил 9 сар
2033	24 жил
2034	24 жил 3 сар
2035	24 жил 6 сар
2036	24 жил 9 сар
2037	25 жил

**10-20 ЖИЛ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛСӨН ДААТГУУЛАГЧИЙН ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ НАС**

Эрэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас	Эмэгтэй даатгуулагчийн төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1964	61 нас 9 сар	1969	56 нас 9 сар
1965	62 нас	1970	57 нас
1966	62 нас 3 сар	1971	57 нас 3 сар
1967	62 нас 6 сар	1972	57 нас 6 сар
1968	62 нас 9 сар	1973	57 нас 9 сар
1969	63 нас	1974	58 нас
1970	63 нас 3 сар	1975	58 нас 3 сар
Жил бүр 3 сараар нэмэгдэн 1977 он ба түүнээс хойш төрсөн бол <b>65 настай</b> тэтгэвэр тогтоолгоно		Жил бүр 3 сараар нэмэгдэн 2002 он ба түүнээс хойш төрсөн бол <b>65 настай</b> тэтгэвэр тогтоолгоно	

**Жишээ:**



- 1965 онд төрсөн даатгуулагч (эрэгтэй) "А" нь нийтдээ 30 жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бол **60 нас** хүрээд 2025 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.
- Даатгуулагч "Б" 1965 онд төрсөн, шимтгэл төлсөн нийт хугацаа нь 18 жил бол тэрээр **62 нас** хүрээд өндөр насны тэтгэврээ хувь тэнцүүлэн тогтоолгоно.

Даатгуулагч 2025 онд дараах нөхцөлийг хангасан тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх нь үүснэ.

**ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР**

**22 жил шимтгэл төлсөн бол**



**10-20 жил шимтгэл төлсөн бол**



## ТЭТГЭВЭР БОДОХ АРГАЧЛАЛ

Өндөр насны тэтгэвэр бодох арга дараах төрөлтэй байна. Үүнд:

- Цалинд үндэслэсэн
- Нэрийн дансны

Даатгуулагч 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө төрсөн бол цалинд үндэслэсэн аргаар тэтгэврийг нь бодно.

- Цалинд үндэслэсэн аргаар өндөр насны тэтгэврийг тооцохдоо даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн **20 жилийн** доторх аль дуртай дараалсан **5 жилийн** буюу **60 сарын** хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас **45 хувиар** бодож тогтооно.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг **20 жилээс** илүү төлсөн жил тутамд **1.5** хувиар, сар тутамд **0.125** хувиар бодож нэмэгдэл олгоно. (Жишээ 1)

Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг **10–20** хүртэл жил төлсөн, төрсөн ондоо харгалзах насанд хүрсэн даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэврийг шимтгэл төлсөн хугацааг нь харгалзан хувь тэнцүүлэн бодно. (Жишээ 2)

### Жишээ: 1

Даатгуулагч “Б” тэтгэврийн даатгалын шимтгэлийг 30 жил 7 сар төлж байгаад 60 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Түүний тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 1.500.000 төгрөг гэвэл:

- а. 20 жилд ногдох тэтгэвэр:  
 $1.500.000\text{₮} * 45\% = 675.000\text{₮}$
- б. Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:  
 $30 \text{ жил} - 20 \text{ жил} = 10 \text{ жил} * 1.5\% = 15\% \quad 1.500.000\text{₮} * 15\% = 225.000\text{₮}$
- в. Илүү ажилласан сард ногдох тэтгэвэр:  
 $7 \text{ сар} * 0.125\% = 0,875\% \quad 1.500.000\text{₮} * 0.875\% = 13.125\text{₮}$
- г. Авах тэтгэврийн хэмжээ:  
 $675.000\text{₮} + 225.000\text{₮} + 13.125\text{₮} = 913.125\text{₮}$

“Б”-д сар бүр **913.125** төгрөгийн тэтгэвэр олгоно.

### Жишээ: 2

Даатгуулагч “Э” тэтгэврийн даатгалын шимтгэлийг 18 жил төлсөн бөгөөд хуульд заасан төрсөн ондоо харгалзах насны болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Түүний тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 1.500.000 төгрөг гэвэл:

- а. 20 жилд ногдох тэтгэвэр:  
 $1.500.000\text{₮} * 45\% = 675.000\text{₮}$
- б. Шимтгэл төлбөл зохих хугацааны нийт сарын тоо:  
 $20 \text{ жил} * 12 \text{ сар} = 240 \text{ сар}$
- в. Нэг сард ногдох тэтгэвэр:  $675.000\text{₮} : 240 \text{ сар} = 2812.5\text{₮}$
- г. “Э”-ийн шимтгэл төлж ажилласан сарын тоо:  $18 \text{ жил} * 12 \text{ сар} = 216 \text{ сар}$
- д. Сард олгох өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр:  
 $2812.5\text{₮} * 216 \text{ сар} = 607.500\text{₮}$

“Э”-ийн тэтгэврийг хувь тэнцүүлэн бодож сар бүр **607.500** төгрөгийн тэтгэвэр олгоно.

- Нэрийн дансны аргаар 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийг дараах томъёогоор бодно.

$$T_{\text{нд}} = \text{НД}_{\text{сз}} / 12K$$

$T_{\text{нд}}$  - нэрийн дансны аргаар тооцсон сарын тэтгэврийн хэмжээ

$\text{НД}_{\text{сз}}$  - нэрийн дансны тухайн жилийн эцсийн үлдэгдэл болон мөнгөжүүлсэн орлогын нийлбэр дүн;

K - тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл.

*(Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл жил бүр тогтооно)*

- 1960 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 1979 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд төрсөн, мөн хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа даатгуулагчийн хувьд цалинд үндэслэсэн болон нэрийн дансны аргаас өөрөө сонгож тэтгэврээ бодуулж болно.

Олон хүүхэд төрүүлж, өсгөсөн эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, тэтгэврийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-аас доошгүй жил төлсөн эхчүүдийн шимтгэл төлж ажилласан хугацааг төрүүлж, өсгөсөн хүүхэд бүрийн тоогоор 1 жил 6 сараар нэмэгдүүлэн тооцож тэтгэврийг тогтоодог.



**1 хүүхэд**  
**1 жил 6 сар**



**2 хүүхэд**  
**3 жил**



**3 хүүхэд**  
**4 жил 6 сар**



**4 хүүхэд**  
**6 жил**

**Жишээ:**

Даатгуулагч "А" 50 настай, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 27 жил төлж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор нийгмийн даатгалын байгууллагад хүсэлтээ гаргажээ. Тэрээр 2 хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд тэтгэвэр тогтоолгох сарын дундаж цалин нь 1.800.000 төгрөг гэвэл:

а. Нийт шимтгэл төлж ажилласан жил:

$$27 \text{ жил} + 3 \text{ жил} (2 \text{ хүүхэд} * 1 \text{ жил } 6 \text{ сар}) = \mathbf{30 \text{ жил}}$$

б. 20 жилд ногдох тэтгэвэр:

$$1.800.000\text{₮} * 45\% = \mathbf{810.000\text{₮}}$$

в. Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:

$$30 \text{ жил} - 20 \text{ жил} = 10 \text{ жил} * 1,5\% = 15\%$$

$$1.800.000\text{₮} * 15\% = \mathbf{270.000\text{₮}}$$

г. Нийт тэтгэвэр:

$$810.000 + 270.000 = \mathbf{1080.000\text{₮}}$$

## ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВРИЙН ТУСГАЙ ЗОХИЦУУЛАЛТ

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч гэр бүлийн аль нэг нь нас барсан тохиолдолд түүний авч байсан тэтгэврээс 20 хувиар тооцсон дүнгээр нөхөр эсхүл эхнэрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ.

- ✓ **20 ба түүнээс дээш жил** хамт амьдарсан
- ✓ Гэр бүл болсноо **бүртгүүлж, батлуулсан**
- ✓ Хоёулаа **нийгмийн даатгалын сангаас** өндөр насны тэтгэвэр авдаг байх



### Жишээ:

Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч “Д”, “Б” нар 30 жил хамт амьдарсан бөгөөд эхнэр “Б” нь өвчний учир нас барсан байна.

Тэтгэвэр авагч “Д” нь сард 1.150.000 төгрөгийн, “Б” нь 900.000 төгрөгийн тэтгэвэр авдаг байсан гэвэл өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалтаар “Д”-ийн тэтгэврийг дараах байдлаар нэмэгдүүлэн олгоно:

а. Тэтгэвэр авагч “Б”-ийн авч байсан тэтгэврийн 20%:

$$900.000\text{₮} * 20\% = \mathbf{180.000 \text{ төгрөг}}$$

б. Тэтгэвэр авагч “Д”-д сард олгох тэтгэвэр:

$$1.150.000\text{₮} + 180,000 = \mathbf{1.330.000\text{₮} \text{ төгрөг}}$$



## ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

**Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр** гэж даатгуулагчийг хөдөлмөрийн чадваргүй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл нийгмийн баталгааг нь хангах зорилгоор тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.



### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР АВАХ ЭРХ

Даатгуулагч ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа **50 ба түүнээс дээш** хувиар байнга буюу удаан хугацаагаар алдсан тохиолдолд түүний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.

Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр	Хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэвэр
<ul style="list-style-type: none"> <li>Тэтгэврийн даатгалын шимтгэлийг <b>20</b> ба түүнээс дээш жил төлсөн бол</li> <li>Эсхүл хөдөлмөрийн чадвараа алдахын өмнөх сүүлийн <b>5</b> жилд нийтдээ <b>36</b> ба түүнээс дээш сар төлсөн бол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн чадвараа алдахаас өмнө нийтдээ <b>36</b> ба түүнээс дээш сар төлсөн бол</li> </ul>



### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДАЛТЫГ ТОГТООХ

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛ тогтооно.

#### Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг:

- ✔ **70 ба түүнээс дээш** хувиар тогтоосон тохиолдолд хөдөлмөрийн чадвараа **бүрэн** алдсан;
- ✔ **70 хүртэл** хувиар тогтоосон тохиолдолд хөдөлмөрийн чадвараа **хагас** (хэсэгчлэн) алдсан гэж үзнэ.

### ТЭТГЭВЭР БОДОХ АРГАЧЛАЛ

Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэврийг тооцохдоо хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн хувьд өндөр насны тэтгэвэр бодох аргачлалаар буюу сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын **45** хувиар тогтоож, **20**-иос илүү ажилласан жил тутамд **1.5** хувиар, сар тутамд **0.125** хувиар бодож нэмэгдэл олгоно. (Жишээ 1)

Харин даатгуулагч нь хөдөлмөрийн чадвараа хагас алдсан тохиолдолд тэтгэврийг дээр дурдсан хэмжээнээс хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээгээр бодож тогтооно. (Жишээ 2)

**Жишээ 1:**

Даатгуулагч ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 75 хувиар алдсан, нийтдээ 28 жил шимтгэл төлж ажилласан, дундаж цалин нь 2.000.000 төгрөг гэвэл:

- а. Өндөр насны тэтгэвэр бодох хувьд ногдох хэсэг:  
 $2.000.000\text{₮} * 45\% = \mathbf{900.000\text{₮}}$
- б. Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:  
 $25 \text{ жил} - 20 \text{ жил} = 8 \text{ жил} * 1,5\% = 12\%$   
 $2.000.000\text{₮} * 12\% = \mathbf{240.000\text{₮}}$
- в. Сард олговол зохих хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр:  
 $\mathbf{900.000\text{₮} + 240.000\text{₮} = 1.140.000\text{₮}}$

*\*ХЧАлдалтын хувь нь 75% байгаа нь **бүрэн алдалт** гэж ойлгоно.*

**Жишээ 2:**

Даатгуулагч ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 65 хувиар алдсан, нийтдээ 28 жил шимтгэл төлж ажилласан, дундаж цалин нь 2.000.000 төгрөг гэвэл:

- а. Өндөр насны тэтгэвэр бодох хувьд ногдох хэсэг:  
 $2.000.000\text{₮} * 45\% = \mathbf{900.000\text{₮}}$
- б. Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:  
 $25 \text{ жил} - 20 \text{ жил} = 8 \text{ жил} * 1,5\% = 12\%$   
 $2.000.000\text{₮} * 12\% = \mathbf{240.000\text{₮}}$
- в. Сард олговол зохих хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр:  
 $\mathbf{(900.000\text{₮} + 240.000\text{₮}) * 65\% = 741.000\text{₮}}$

*\*ХЧАлдалтын хувь нь 65% байгаа нь **хагас алдалт** гэж ойлгоно.*

Хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэврийг өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр бодох аргачлалаар тооцсон тэтгэврийн хэмжээнээс хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан даатгуулагчийн хувьд 100 хувиар, хагас алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тус тус бодож тогтооно.

**Жишээ 3:**

Даатгуулагч ердийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа 65 хувиар алдсан, нийтдээ 19 жил 7 сар шимтгэл төлж ажилласан, дундаж цалин нь 2.000.000 төгрөг гэвэл:

- а. 20 жилд ногдох тэтгэвэр:  $2.000.000\text{₮} * 45\% = \mathbf{900.000\text{₮}}$
- б. Шимтгэл төлбөл зохих хугацааны нийт сарын тоо:  
 $20 \text{ жил} * 12 \text{ сар} = \mathbf{240 \text{ сар}}$
- в. Нэг сард ногдох тэтгэвэр:  $900.000\text{₮} : 240 \text{ сар} = \mathbf{3.750\text{₮}}$
- г. "Б"-ийн шимтгэл төлж ажилласан сард ногдох тэтгэвэр  
 $(19 \text{ жил} * 12 \text{ сар}) + 7 \text{ сар} = \mathbf{235 \text{ сар}}$   $3.750\text{₮} * 235 \text{ сар} = \mathbf{881.250\text{₮}}$
- д. Сард олгох хөдөлмөрийн чадвар алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэвэр:  $881.250\text{₮} * 65\% = \mathbf{572.812\text{₮}}$

## ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

**Тэжээгчээ алдсаны тэтгэвэр** гэж даатгуулагчийг нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн нийгмийн баталгааг нь хангах зорилгоор тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.



Нас барсан тэжээгчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааран түүний асрамжид байсан гэр бүлийн гишүүдэд тэжээгчээ алдсаны тэтгэврийг бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоодог.

Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр	Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэвэр
<ul style="list-style-type: none"> <li>Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос доошгүй жил төлсөн бол</li> <li>Эсхүл нас барахын өмнөх <b>5</b> жилд нийтдээ <b>36</b> ба түүнээс дээш сар шимтгэл төлсөн бол</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ <b>60</b>-аас доошгүй сар, үүнээс <b>12</b> сар нь тасралтгүй төлсөн даатгуулагч нас барсан бол</li> </ul>

### ТЭЖЭЭГЧИЙН ГЭР БҮЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАРГҮЙ ГИШҮҮД

**1** Төрсөн, дагавар, үрчлэн авсан **19** нас хүрээгүй хүүхэд (үүнд эцгээ нас барснаас хойш төрсөн **хүүхэд** хамаарна)

**3** Тэжээгчийг нас барахын өмнө тэтгэврийн насанд хүрсэн, эсхүл хөдөлмөрийн чадвараа **50** ба түүнээс дээш хувиар алдаж хөгжлийн бэрхшээлтэй болсон **эхнэр, нөхөр**, тэжээн тэтгэх өөр хүнгүй **эцэг, эх**

**2** Тэжээгчийн асрамжид байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл **19** нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон **төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд**

**4** Тэжээгчийн хууль ёсоор асран хамгаалж, харгалзан дэмжиж байсан төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, эсхүл **19** нас хүрээгүй байхдаа хөгжлийн бэрхшээлтэй болсон **ач, зээ**

## ТЭТГЭВЭР БОДОХ АРГАЧЛАЛ

Тэжээгчээ алдсаны тэтгэврийг өндөр насны тэтгэвэр бодох аргачлалаар буюу сарын дундаж хөдөлмөрийн хөлс, орлогын 45 хувиар тогтоож, 20-иос илүү ажилласан жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл тооцсон хэсгээс хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан тогтоосон доор дурдсан хувь хэмжээгээр бодно. (Жишээ 1)

Гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо	Тэтгэвэр бодох хувь
3 ба түүнээс дээш	100%
2	75%
1	50%

Тэжээгчээ алдсаны хувь тэнцүүлсэн тэтгэврийг өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэр бодох аргачлалаар тооцсон тэтгэврийн хэмжээнээс гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоог харгалзан 50 хувь, 75 хувь, 100 хувиар тус тус бодож тогтооно. (Жишээ 2)

### Жишээ 1:

Даатгуулагч “Д” 25 жил шимтгэл төлж байгаад ердийн өвчний улмаас нас барсан. Түүний ар гэрт насанд хүрээгүй 2 хүүхэд үлдсэн бөгөөд дундаж цалин нь 2.000.000 төгрөг гэвэл:

а. 20 жилд ногдох тэтгэвэр:

$$2.000.000\text{₮} * 45\% = \mathbf{900,000\text{₮}}$$

б. Илүү ажилласан жилд ногдох тэтгэвэр:

$$25 \text{ жил} - 20 \text{ жил} = 5 \text{ жил} * 1.5\% = \mathbf{7.5\%}$$

$$2.000.000 * 7.5\% = \mathbf{150,000}$$

в. Өндөр насны тэтгэвэр бодох хувьд ногдох хэсэг:

$$900.000 + 150.000 = 1.050.000\text{₮}$$

г. Сард олговол зохих тэжээгчээ алдсаны тэтгэвэр:

$$1.050.000\text{₮} * 75\% (2 \text{ хүүхэдтэй}) = \mathbf{787.500\text{₮}}$$

### Жишээ 2:

Даатгуулагч “Д” 17 жил 2 сар шимтгэл төлж байгаад ердийн өвчний улмаас нас барсан. Түүний ар гэрт насанд хүрээгүй 2 хүүхэд үлдсэн бөгөөд дундаж цалин нь 2.000.000 төгрөг гэвэл:

а. 20 жилд ногдох тэтгэвэр:

$$2.000.000 * 45\% = \mathbf{900.000\text{₮}}$$

б. Шимтгэл төлбөл зохих хугацааны нийт сарын тоо:

$$20 \text{ жил} * 12 \text{ сар} = \mathbf{240 \text{ сар}}$$

в. Нэг сард ногдох тэтгэвэр:  $900.000\text{₮} : 240 \text{ сар} = \mathbf{3750\text{₮}}$

г. “Б”-ийн шимтгэл төлж ажилласан сарын тоо

$$(17 \text{ жил} * 12 \text{ сар}) + 2 \text{ сар} = \mathbf{206 \text{ сар}}$$

д. Сард олгох тэтгэвэр:

$$3750\text{₮} * 206 \text{ сар} = \mathbf{772,500\text{₮}}$$

е.  $772,500\text{₮} * 75\% (2 \text{ хүүхэд}) = \mathbf{579375\text{₮}}$

## ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХОД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

### ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- Хэрэв хөдөлмөрийн дэвтрээ үрэгдүүлсэн бол архивын лавлагаа, эсхүл ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр
- Ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэр
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- Хэрэв хөдөлмөрийн дэвтрээ үрэгдүүлсэн бол архивын лавлагаа, эсхүл ажилласан хугацааг сэргээн тогтоосон тухай шүүхийн шийдвэр
- Ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тухай тушаал, шийдвэр
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадласан шийдвэрийн хуудас
- Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан бол үйлдвэрлэлийн осол тогтоосон акт

### ТЭЖЭЭГЧЭЭ АЛДСАНЫ ТЭТГЭВЭР

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Тэжээгч 1995 оноос өмнө ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр
- 1995 оноос өмнөх хугацааны цалингаар тэтгэврээ тогтоолгох бол дараалсан 5 жилийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхойлолт
- Тэжээгч цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа
- Асран хамгаалагчаар тогтоосон тухай харьяа аймаг, сум, дүүргийн Засаг даргын захирамж
- Тэжээгчээ алдсаны тэтгэврийг хөдөлмөрийн чадваргүй гишүүдэд хуваан олгох тохиолдолд холбогдох хүсэлт, шүүхийн шийдвэр

### МАЛЧИН ДААТГУУЛАГЧИЙН ТЭТГЭВЭР

- Өргөдөл
- Иргэний үнэмлэх
- Хөдөлмөрийн дэвтэр (1995 оноос өмнөх)
- 1995 оноос хойших хугацаанд мал маллаж, шимтгэл төлж байсан хугацааг нь нотлох боломжгүй бол аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн тогтоол
- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1990-1994 оныг нөхөн тооцуулсан бол тухайн орон нутагт мал маллан оршин сууж байсан тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт
- “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогын бүртгэл” “А” данс малчны гэр бүлийн гишүүдийн мэдээллийг “А” дансны 2 дугаар бүлэг дэх “Малчны мэдээлэл” хэсэгт бүртгэгдсэн хүний мэдээлэлтэй тулган гаргасан лавлагаа
- Цэрэгт алба хаасан бол цэргийн батлах, эсхүл тусгай архивын лавлагаа
- Тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан эмэгтэй малчин даатгуулагчийн хувьд гэрлэлтийн баталгаа байхгүй тохиолдолд гэрлэсэн эсэх тухай шүүхийн шийдвэр.

## ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

**ТЭТГЭМЖ** гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид тэтгэмжийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Тэтгэмжийн даатгалын сангаас даатгуулагчид олгох тэтгэмж нь доор дурдсан 3 төрөлтэй байна. Үүнд:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж

### ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР ТҮР АЛДСАНЫ ТЭТГЭМЖ

Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө тэтгэмжийн даатгалын шимтгэлийг дараалсан **3 ба түүнээс дээш** сарын хугацаагаар төлсөн даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.



Мөн даатгуулагч эх хүүхдээ **196 хоног** хүртэл тээгээгүй дутуу төрүүлсэн буюу эрүүл мэндийн шалтгаанаар үр хөндүүлсэн бол хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрхтэй.

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг даатгуулагчийн тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанаас хамааралтайгаар сүүлийн дараалсан 3 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас доор дурдсан хувь хэмжээгээр бодно.

Тэтгэмжийн даатгалын шимтгэл төлсөн хугацаа (сараар)	Тэтгэмж бодох хэмжээ (хувиар)
3-59	50
60-119	55
120-179	60
180 ба түүнээс дээш	75

Тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар	Ажлын 66 өдрөөс хэтрэхгүй
Хуанлийн жилд удаа дараа өвчилсөн тохиолдолд	Ажлын 132 өдрөөс илүүгүй
Хорт хавдар, сүрьеэгээр анх өвчилсөн, бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор болсон тохиолдолд	Ажлын 132 өдрөөс хэтрэхгүй

Ердийн өвчин, ахуйн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөний улмаас эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас ажлын 10 өдрийн дотор цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бичиж олгоно.

**Жишээ:**

Даатгуулагч **5 жил (60 сар)** тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж байгаад ердийн өвчний улмаас хуанлийн **14 хоног** эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, эмнэлгийн хуудас бичүүлсэн гэвэл:

Шимтгэл төлсөн сүүлийн 3 сар	Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого (төгрөгөөр)
1	1,800,000
2	1,850,000
3	1,870,000
<b>Нийт</b>	<b>5,520,000</b>

а. Дундаж цалин

$$5.520.000 : 3 = \mathbf{1.840.000}$$

б. Нэг өдөрт ногдох цалин:

$$1.840.000\text{₮} : 21 \text{ хоног} = \mathbf{87.619\text{₮}}$$

в. Тэтгэмж бодох хувь: 60 сар - **55%**

г. Нэг өдөрт ногдох тэтгэмж:

$$87.619\text{₮} * 55\% = \mathbf{48\ 190\text{₮}}$$

д. Эмнэлгийн хуудас бичсэн 14 хоногийн доторх ажлын өдөр: **10**

е. Олговол зохих тэтгэмж:

$$48\ 190\text{₮} * 10 \text{ өдөр} = \mathbf{481\ 900\text{₮}}$$



## ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ ТЭТГЭМЖ

Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг нийтдээ **12 сар** ба түүнээс дээш хугацаанд, үүнээс жирэмсний амралт авахын өмнөх сүүлийн **6 сард** тасралтгүй төлсөн даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.



Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг жирэмсний амралт авсан сарын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн **12** сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас **100** хувиар тооцож, 120 хоногийн, ихэр хүүхэд төрүүлсэн бол **140** хоногийн хугацаанд ажлын өдрөөр тооцон олгоно.

Даатгуулагч эхэд жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг жирэмсний амралт эхэлснээс хойш болон амаржсаны дараа 30 хүртэл хоногийн дотор жирэмсэн болон төрөлтийн үеийн эх барихын тусламж, үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагаас цахимаар эсхүл цаасан хэлбэрээр бичиж олгоно.

### Жишээ:

Даатгуулагч эх 6 жил тасралтгүй тэтгэмжийн даатгалын шимтгэл төлж ажилласан, түүний сүүлийн 12 сарын хөдөлмөрийн хөлсний дундаж 1.500.000 төгрөг, түүнд жирэмсний эмнэлгийн хуудсыг 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс хуанлийн 60 хоногоор бичиж олгосон гэвэл:

а. Сарын ажлын өдрийн дундаж хоног:

**21 хоног**

б. Нэг өдөрт ногдох хөдөлмөрийн хөлс, орлого:

$1.500.000\text{₮} : 21 \text{ хоног} = \mathbf{71.429\text{₮}}$

в. Тэтгэмж олгох хоног:

**43 өдөр** (эмнэлгийн хуудсанд бичигдсэн хугацаан дахь ажлын өдрөөр тооцно)

г. Олговол зохих тэтгэмж:

$\mathbf{71.429\text{₮} * 43 \text{ өдөр} = \mathbf{3.071.447\text{₮}}$



Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцох бөгөөд хэрэв тэтгэмж олгох хугацаанд нийтээр тэмдэглэх баярын өдөр тохиосон бол уг өдрийг ажлын өдөртэй адилтган тооцож, тэтгэмжийг бодно.